

## ГАДААДЫН АРБИТРЫН ШИЙДВЭРИЙГ МОНГОЛ УЛСАД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, БИЕЛҮҮЛЖ БУЙ ПРАКТИК, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### RECOGNIZING AND ENFORCING FOREIGN ARBITRAL AWARDS IN MONGOLIA: AN ANALYSIS

#### С.Энхцэцэг\*

Дотоод хэргийн их сургуулийн докторант, МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын дарга

Enkhtsetseg S, Ph.D Candidate in Law, University of Internal Affairs, Chairman of the Mongolian Interational Arbitration Centre, MNCCI

\*Хариуцлагатай зохиогч: su.enkh@yahoo.com

**Хураангуй:** Гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлоготой улсууд гадаадын арбитрын шийдвэрийг үндэсний хэмжээнд биелүүлэх талаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход анхаарах болсон. Монгол Улсын нэгдэн орсон “Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх тухай” 1958 оны Нью-Йоркын конвенцод 1994 онд нэгдэн орсон. Конвенцын 3 дугаар зүйлд зааснаар тус конвенцод нэгдэн орсон улсуудад гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэх журмаа тус конвенцод нийцүүлэн үндэсний хууль тогтоомжоор тодорхойлох эрхийг олгосон. Гэтэл манай улс энэхүү эрхээ эдлэхгүй эрх зүйн хэм хэмжээг конвенцын зохицуулалтыг хуулбарлах байдлаар тогтоосон. Нөгөө талаас гадаадын арбитрын шийдвэрийг Монгол Улс үндэслэлгүйгээр /олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан/ биелүүлэхгүй байх нь Монгол Улс НҮБ-ын гишүүн орныхоо хувьд олон улсын гэрээний үүргээ зөрчиж, Монгол Улсын нэр хүнд олон улсын хэмжээнд буурах, хуулийн засаглалын олон улсын судалгаанд доогуур эрэмбэлэгдэх, улмаар бусад сөрөг үр дагаврууд үүсэх эрсдэлтэй учраас гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь чухал ач холбогдолтой болно. Энэхүү өгүүлэлд Монгол Улсад гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлсэн болон биелүүлэхээс татгалзсан шүүхийн шийдвэр болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дүн шинжилгээ хийж, практикт тулгарч буй асуудал, шийдвэрлэх зарим арга замыг тодорхойлохыг зорилоо.

**Abstract:** Countries with policies aimed at attracting foreign investment have started to focus on improving legal frameworks for the enforcement of foreign arbitration decisions at the national level. Mongolia ratified The New York Convention /1958/ on the Recognition and Enforcement of Foreign Arbitral Awards in 1994. According to the Article 3 of the 1958 NY Convention grants member states the authority to define the procedures for enforcing foreign arbitral awards in accordance with its provisions through national legislation. However, our country has established a legal framework by replicating the provisions of the Convention, without exercising this right. In other words, the national legal framework lacks detailed regulation. On the other hand, failure by Mongolia to enforce foreign arbitral awards without justification (as stipulated in both international and national legislation) would constitute a violation of its obligations under international treaties as a member of the United Nations. This could harm Mongolia’s international reputation, lower its ranking in international rule-of-law assessments, and expose it to other negative consequences. Therefore, it is crucial to improve the legal framework to ensure the enforcement of foreign arbitral awards. The aim of this article is to identify the practical challenges and potential solutions in the enforcement of foreign arbitral awards in Mongolia by analyzing court decisions, both those that have been successfully enforced and those that have been refused, as well as the execution of related court rulings.



Дотоод Хэргийн Их Сургууль  
 Улсын Гэрээний Зөвлөл



**Түлхүүр үг:** Олон улсын арбитр, арбитрын шийдвэр, арбитрын шийдвэрийн шийдвэрийн биелэлт, гадаадын арбитрын шийдвэр, эрх зүйн зохицуулалт

**Keywords:** International arbitration, arbitral award, the recognition and enforcement of arbitral awards, foreign arbitral award, legal regulation

### Үндэслэл

Улс орны эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдал, өсөлт, хөгжлийн гарц нь үндэсний үйлдвэрлэл, гадаадын хөрөнгө оруулалт, гадаад, худалдаа юм. Энэ хэрээр тэдгээрт чиглэсэн төрийн бодлого, дэмжлэг, эрх зүйн орчин, маргаан шийдвэрлэх механизм нь боловсронгуй байх шаардлагатай.

Аливаа улсын хөрөнгө оруулалт татах боломж, бизнес эрхлэх орчны таатай эсэх үнэлгээг Дэлхийн банкны “Doing business” судалгааны 12 үзүүлэлтийн нэг болох тухайн улс бизнесийн маргааныг хэрхэн шуурхай, зардал багатай шийдвэрлэж буйгаар хэмжиж байна. (Дэлхийн банк, 2020)

Өнөөдөр эдийн засгийн өндөр хөгжилтэй улс оронд олон улсын болон үндэсний арбитрууд үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж хөгжсөөр байна.

УИХ-аас 1995 онд Гадаад худалдааны арбитрын тухай хууль батлагдсанаар Монгол Улсад ганц арбитр ажиллах болсон нь тухайн үеийн Гадаад Худалдааны Арбитр /одоогийн Монголын Олон Улсын Арбитр/ юм. 1995 оноос хойш тус арбитр гадаад эдийн засгийн хэлцлээс үүдсэн болон гадаадын хөрөнгө оруулалттай компанийн маргааныг хянан шийдвэрлэж байв. (Энхцэцэг, Доржготов, Мэндсайхан, 2020)

Арбитр нь шүүхтэй харьцуулахад харьцангуй уян хатан, чөлөөт тогтолцоо боловч арбитраар маргаан шийдвэрлүүлэх зарчмын шинжтэй харилцаануудыг НҮБ-ын Олон Улсын Худалдааны Эрх Зүйн Комисс /ОУХЭЗК/ /UNCITRAL/-оос загварлан хуульчилж гишүүн орнуудаа Олон улсын арилжааны арбитрын тухай загвар хууль (цаашид “НҮБ-ын Арилжааны арбитрын загвар хууль” гэх)-д нийцүүлэн үндэсний Арбитрын хуулиа батлахыг санал болгосон байна.

УИХ-аас 2003 онд Арбитрын тухай хуулийг анх удаа баталж 2017 онд шинэчлэн найруулснаар Монгол Улсын арбитрын эрх зүйн орчинд тодорхой өөрчлөлт орсон. Тус хууль нь НҮБ-ын Арилжааны арбитрын загвар хуулийг Монгол Улсад нутагшуулсан, орчин үеийн арбитрын зарчим, үзэл баримтлалтай нийцсэн хууль болсон байна. (Уянга, Нинжин, 2024)

Олон улсын худалдаа, эдийн засгийн харилцаа өргөжин тэлэх тусам гэрээний харилцаа дан ганц хүн, хуулийн этгээдийн хооронд бус Засгийн газар болон гадаадын хуулийн этгээд хооронд хийгдэх хандлага нэмэгдэж байна. Гэрээний талууд маргаан гарсан тохиолдолд цаг хугацаа, зардал, нууцлалын хувьд илүү үр дүнтэй гэж үзэн арбитраар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх хандлага нэмэгдэхийн хэрээр маргааныг арбитраар шийдвэрлүүлэх олон улсын олон талт болон 2 талт гэрээ, конвенцууд байгуулагдсаар байна.

Арбитраар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд талууд өөрсдөө арбитраар, дүрмээ болон эрх зүйн хэм хэмжээгээ сонгодог учир маргаан хянан шийдвэрлэхэд өөр байгууллагын оролцоо шаарддаггүй.

Харин арбитрын шийдвэрийг баталгаажуулах, гүйцэтгэх ажиллагаа шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага буюу хөндлөнгийн этгээдийн оролцоотой явагддаг.

Монгол Улсын хувьд 2017 оны “Арбитрын тухай хууль”-ийг шинэчлэн баталсан нь тус хуулийн хүрээнд өмнөх 2003 оны Арбитрын тухай хуультай харьцуулахад арбитрын шийдвэрийг баталгаажуулах, гүйцэтгэх гэсэн агуулгыг тусгаж өгснөөрөө шинэлэг юм (Болормаа, 2022).

Монгол Улс 1994 онд Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч,

биелүүлэх тухай 1958 оны Нью-Йоркын конвенцод нэгдэн орсон (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 1994) тул Монгол Улсын арбитрын шийдвэр нь тус конвенцын гишүүн болох дэлхийн 172 гаруй улсад заавал биелэгдэх хүчинтэй.

Арбитрын шийдвэрийг шүүхээр баталгаажуулах, гүйцэтгэх хуудас бичих, гүйцэтгэх ажиллагааны талаар Монгол Улсын хувьд Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай 1958 оны Нью-Йоркын конвенцыг удиртгал болгон Арбитрын тухай (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2017), Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2022) болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2017) хуулиар тус тус зохицуулж байна.

НҮБ, Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай конвенц (1958)-ийн 3 дугаар зүйлд “хэлэлцэн тохирогч улс бүр арбитрын шийдвэрийг заавал биелүүлэх шийдвэр гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд түүнийг өөрийн улсын хэрэг хянан шийдвэрлэх эрхийн хэм хэмжээг баримтлан биелүүлнэ.” гэж зааснаар оролцогч улс бүрд заавал хүлээн зөвшөөрөх, биелүүлэх үүргийг хүлээлгэсэн ч ямар процессоор хэрэгжүүлэхийг тухайн улсын эрх зүйн зохицуулалтын хувьд нээлттэй үлдээсэн байдаг.

2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дах хэсэгт “Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан буюу зохигч хэлэлцэн тохиролцсон бол иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитр шийдвэрлэнэ.”, мөн

хуулийн 184 дүгээр зүйлийн 184.1 дэх хэсэгт “Эрх зүйн маргааныг энэ хуулийн 13.2-т зааснаар арбитр шийдвэрлэсэн ... бол шүүхээр баталгаажуулах”-аар, мөн 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.2.3, Арбитрын тухай хуулийн 48, 49 дүгээр зүйлд үндэслэн гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэж байна.

Ийнхүү зохицуулахдаа гадаадын болон дотоодын арбитрын шийдвэрийг баталгаажуулах, гүйцэтгэх ажиллагааг ялгаж зааглаагүй, гадаад улсад хянан шийдвэрлэсэн арбитрын шийдвэрийг хэрхэн гүйцэтгэх, баталгаажуулах процесс ажиллагаа хууль тогтоомжийн хүрээнд ойлгомжгүй, хийдэлтэй асуудал байна.

**Нэг. Гадаадын арбитрын шийдвэрийг Монгол Улсад хүлээн зөвшөөрч, биелүүлж буй практик, түүнд хийсэн дүн шинжилгээ**

Энэхүү өгүүлэлд нийтэд ил болсноос бусад хэргийн оролцогчдын нэрийг нууцлав.

Гадаад улсын арбитрын шийдвэртэй, Монгол Улсын шүүхээр 2011-2024 оны 4 дүгээр сарын хооронд баталгаажуулсан шүүгчийн захирамжид дүн шинжилгээ хийсэн. 2011 оноос 2024 оны 4 дүгээр сар хүртэл Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба нь гадаад улсын арбитрын нийт 96 шийдвэрт гүйцэтгэх ажиллагаа явуулж 35 шийдвэрийг гүйцэтгэсэн байна. (НШШГГ, Гадаад улсын арбитрын шийдвэрийн гүйцэтгэх ажиллагааны статистик, 2024) (График 2-с үзнэ үү)




График 1. Улсын хэмжээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдсан гадаад улсын арбитрын шийдвэрийн тоо (2011-2024 оны 4 дүгээр сар)



МОНГОЛ УЛСЫН АРБИТРЫН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК



Үндэсний Арбитрын Төв  
 National Arbitration Center

2011-2024 оны 4 дүгээр сарын хооронд Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь гадаад улсын арбитрын нийт 96 шийдвэр, Монгол Улсын арбитрын

нийт 734 шийдвэрт шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан байна. (График 3-с үзнэ үү)




График 2. Улсын хэмжээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдсан гадаадын болон Монгол Улсын арбитрын шийдвэрийн тооны харьцаа

2011-2024 оны хооронд Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь гадаад улсын арбитрын 96 шийдвэрийн 33 шийдвэрийг биелүүлж, 41 шийдвэрийг доорх үндэслэлээр гүйцэтгэх

ажиллагаанаас хассан /төлбөр авагчид буцаасан, хэрэгсэхгүй буюу хүчингүй болсон, харьяаллын дагуу шилжүүлсэн, түдгэлзүүлсэн/ байна. (График 2-с үзнэ үү)



График 3. Гадаад улсын арбитрын шийдвэрийн биелэлтийн байдал (2011-2024)

Дээр дурдсан арбитрын шийдвэрийн биелэлт болон татгалзалтай холбоотой ямар ажиллагаа хийгдэж байгаа болон практикт тохиолддог асуудлыг илүү тодорхой болгох үүднээс хэд хэдэн шүүхийн шийдвэрийг сонгон авч дүн шинжилгээ хийлээ.

төлөөлөгч М, Б нарын гаргасан хүсэлтийг шийдвэрлэсэн байна.

Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 2017 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр Лондоны Олон Улсын Арбитрын шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн №UN153003 дугаар шийдвэр баталгаажуулах Европын сэргээн босголт хөгжлийн банкны

НҮБ, Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх тухай конвенц (1958)-ын 3 дугаар зүйл, Арбитрын тухай хуулийн 48.1 дэх хэсэгт заасны дагуу “Аль улсад гаргаснаас үл хамааран арбитрын үндсэн шийдвэрийг заавал биелүүлэх хүчинтэй гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд харьяалах шүүхэд бичгээр өргөдөл гаргаснаар энэ хуулийн 48, 49 дүгээр зүйл болон конвенцод заасан журмын дагуу арбитрын үндсэн шийдвэрийг гүйцэтгэнэ”, мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх

тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 184.3 дахь хэсэгт “Арбитрын шийдвэрийг биелүүлэх боломжийг шүүх хянан үзэж хүсэлт ирүүлсэн өдрөөс 7 хоногийн дотор шүүгчийн захирамжаар баталгаажуулна” гэж заасны үндсэн дээр Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 181/ШЗ2017/12823 дугаар шийдвэр гаргасан байна. (Лондоны Олон Улсын Арбитрын шүүхийн шийдвэрийг баталгаажуулах тухай шүүгчийн захирамж, 2017)

Дээрхээс Монгол Улс “Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх тухай” Нью-Йоркын конвенцоор хүлээсэн үүргээ Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасан “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасны дагуу хэрэгжүүлж шүүхээр “Арбитрын шийдвэрийг баталгаажуулах тухай” захирамж гаргаж, шийдвэрийг албадан биелүүлэхийг Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд даалгасан. Гэвч хариуцагч тал шийдвэр гүйцэтгэлийн явцад барьцаа хөрөнгийн үнэлгээнд 2 удаа гомдол гаргаж 3 шатны шүүхээр маргаан шийдэгдсээр өнөөдрийг хүртэл биелэгдээгүй, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн байдалтай байна. (Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, 2024)

Гадаад улсын арбитрын шийдвэртэй, 2000 оноос хойших Монгол Улсын шүүхээр баталгаажуулсан шүүгчийн захирамжид дүн шинжилгээ хийж үзэхэд гадаадын арбитрын шийдвэрийг баталгаажуулах хүсэлтийг шийдвэрлэхдээ шүүхүүд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.3 буюу “шүүх хуралдааны бусад үед хянан шийдвэрлэж

байгаа асуудлаар шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг бичгээр гаргана” гэсэн зохицуулалтыг хэрэглэж байх бөгөөд мөн хуулийн 184 дүгээр зүйл буюу “арбитрын шийдвэрийн гүйцэтгэлийг шүүхээр баталгаажуулах” талаарх зохицуулалтыг хууль зүйн үндэслэл болгон баримталж байна.

Гадаадын арбитрын шийдвэрийг баталгаажуулсан шүүгчийн захирамжуудыг судалж үзэхэд арбитрын шийдвэрийг баталгаажуулах хүсэлтийг шүүхүүд шийдвэрлэхдээ хууль зүйн өөр өөр зохицуулалтыг үндэслэл болгон хэрэглэж байх бөгөөд хууль тогтоомжийн хэрэглээний хувьд дараах байдалтай байна: а) Зөвхөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйл<sup>1</sup> буюу арбитрын шийдвэрийг шүүхээр баталгаажуулах талаарх зохицуулалтыг баримтлан шийдвэрлэж байна. Тухайлбал, Сонгинохайрхан дүүргийн шүүхийн 2010 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн №1855 тоот шүүгчийн захирамжаар Чех Улсын Прага хотын Эдийн засаг, хөдөө аж ахуйн танхимын дэргэдэх арбитрын шүүхийн шийдвэрийг баталгаажуулах хүсэлтийг шийдвэрлэсэн үндэслэлдээ: “...Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 184.2 дахь хэсэгт “шийдвэрийг гүйцэтгүүлэхээр сонирхож буй тал гүйцэтгэлийг баталгаажуулахаар төлбөр төлөгчийн оршин суугаа газрын харьяалах шүүхэд хүсэлтээ гаргах эрхтэй гэж заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг хүлээн авах үндэслэлтэй байна...” гэж тодорхойлон арбитрын шийдвэрийг баталгаажуулж шийдвэрлэсэн байна (Сонгинохайрхан дүүргийн шүүх, 2010).

б) Мөн НҮБ, Гадаадын арбитрын байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх тухай конвенц (1958)-ийн 3 дугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3,

<sup>1</sup> 2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйл нь Арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, Гэмт хэргийн хохирогчид нөхөн

төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, захиргааны шийтгэвэр, улсын байцаагчийн төлбөр тогтоосон актын гүйцэтгэлийг шүүхээр баталгаажуулах гэсэн гарчигтай.



МОНГОЛ УЛСЫН АРБИТРЫН ШҮҮХ



МОНГОЛ АРБИТРЫН  
АССОЦИАЦИЙН  
ХУУЛЬ

Арбитрын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 184.3, Олон улсын гэрээнд нэгдэн орох тухай 1994 оны хууль гэсэн бүх зохицуулалтыг баримтлан шийдвэрлэсэн тохиолдол байна. Тухайлбал, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн №181/ШЗ2016/04858 тоот захирамжаар Лондоны олон улсын арбитрын шүүхийн шийдвэрийг баталгаажуулах хүсэлтийг шийдвэрлэсэн үндэслэлдээ “...Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх тухай 1958 оны Нью-Йорк хотноо байгуулагдсан конвенцод Монгол Улс 1994 оны 5 дугаар сарын 26-ны өдөр нэгдэн орсон тухай хууль баталсан байна. Тус хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “Монгол Улс харилцан адил байх зарчмын үндсэн дээр зөвхөн уг конвенцод нэгдэн орсон хэлэлцэн тохирогч нөгөө улсын нутаг дэвсгэрт гарсан арбитрын байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхэд эл конвенцын заалтыг даган мөрдөнө” гэж хуульчилжээ. Лондоны арбитрын шүүх шийдвэрээ ИБУИНВУ-ын Лондон хотод гаргажээ. ИБУИНВУ НҮБ, Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх тухай конвенц (1958)-д нэгдэн орсон юм.

Монгол Улсын нэгдэн орсон НҮБ, Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай конвенц (1958)-ын 3-р зүйлд хэлэлцэн тохирогч улс бүр арбитрын шийдвэрийг заавал биелүүлэх шийдвэр гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд түүнийг өөрийн улсын хэрэг хянан шийдвэрлэх эрхийн хэм хэмжээг баримтлан биелүүлнэ гэж, Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэж”, Арбитрын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7 дах хэсэгт” Анхан шатны шүүх арбитрын шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл

тухайн арбитрын шийдвэрийг баталгаажуулж, ИХШХШТ хуулийн 184 дүгээр зүйлийн 184.3 дах хэсэгт заасан гүйцэтгэх хуудас бичнэ” гэж, ИХШХШТ хуулийн 184 дүгээр зүйлийн 184.3 дах хэсэгт “Арбитрын шийдвэр...улсын байцаагчийн төлбөр тогтоосон актыг биелүүлэх боломжийг нь шүүх хянан үзэж ирүүлсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүгчийн захирамжаар баталгаажуулна” гэж тус тус заажээ.

Иймд “Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн ...Лондоны олон улсын арбитрын шүүхийн ... өдрийн ... дугаар шийдвэрийг баталгаажуулах нь зүйтэй байна” гэж тайлбарласан байна. (Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, 2016)

в)Хоёр улсын хооронд байгуулагдсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээний холбогдох зохицуулалтыг баримтлан шийдвэрлэсэн тохиолдол байна. Тухайлбал, Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн №101/ШЗ2016/32286 тоот захирамжаар Москва хотын арбитрын шүүхийн шийдвэрийг баталгаажуулах хүсэлтийг шийдвэрлэхдээ үндэслэлээ “...Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай 1999.07.08-ны өдрийн гэрээний 36 дугаар зүйлд “Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба гүйцэтгэх тухай хүсэлт”, уг зүйлийн 2.1-д “шийдвэр, эсхүл шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон ба гүйцэтгэвэл зохицыг баталсан түүний баталгаат хуулбар...”-ыг хүсэлт гаргагч нь хүсэлтдээ хавсаргахаар заажээ. Хүсэлт гаргагч нь орчуулж ирүүлсэн, хураамж төлсөн байна. Иймд арбитрын шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг хангах нь зүйтэй байна” гэж тайлбарласан байна. (Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, 2016)

г)Хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах хууль зүйн үндэслэлийг огт дурдалгүйгээр шийдвэр гаргасан тохиолдол ч мөн байна. Тухайлбал, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн шүүгчийн захирамжаар Хонконгийн олон улсын арбитрын шүүхийн шийдвэрийг баталгаажуулах хүсэлтийг шийдвэрлэсэн үндэслэлд “...уг шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай нэхэмжлэгчийн хүсэлтийг хангах нь зүйтэй байна” гэж баталгаажуулсан захирамж гаргасан байна.

**Хоёр. Гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ**

Арбитрын шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх, хэрэгсэхгүй буюу хүчингүй болгох, гүйцэтгэсэн шийдвэрийг цуцлах зэрэг үндэслэлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 31 дүгээр зүйлийн 31.1, 119 дүгээр зүйлд тус тус зохицуулсан байна.

Монгол Улсын шүүхээс гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэхээс татгалзсан хэд хэдэн жишээг дурдъя. Шүүх талуудын хоорондын эрх зүйн маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй байх буюу Конвенцын 5 дугаар зүйлийн 1(е)-д заасны дагуу шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан тохиолдлууд байна.

Тухайлбал, Нэхэмжлэгч Япон Улсын “Иточу” корпорац, хариуцагч Монгол Улсын хуулийн этгээд “Монгол газар” ХХК нар Японы худалдааны арбитраар маргаанаа шийдвэрлүүлж 2011 оны 11 дүгээр сард шийдвэр гарсан. Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтийн дагуу 2012 оны 4 дүгээр сард МУ-ын шүүхээс арбитрын шийдвэрийг баталгаажуулж шүүгчийн захирамж гаргаж гүйцэтгэх хуудас олгожээ. Хариуцагч арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг Токио хотын орон нутгийн шүүхэд гаргасан бөгөөд хэргийг эцэслэн шийдвэрлээгүй

байх үед шийдвэрийг баталгаажуулсан захирамж гаргасан байна гэж үзэж уг захирамжийг хүчингүй болгосон нь хууль ёсны дагуу гарсан шийдвэр гэж үзэж байна.

Мөн гадаадын хөрөнгө оруулалттай “Г” ХХК, Монголын “Б” ХХК хоорондын барилгын ажил хамтран гүйцэтгэхтэй холбоотой маргааныг Швейцарын танхимын дэргэдэх арбитр хянан шийдвэрлээд шийдвэр 2021 оны 10 дугаар сарын 28-нд гарсан. Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгч арбитрын үндсэн шийдвэрийг хүлээн зөвшөөрч баталгаажуулж, гүйцэтгэх хуудас олгох захирамжийг 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр гаргасан. Захирамжийг доорх үндэслэлээр хүчингүй болгохоор хэргийн хариуцагч тал шүүхэд гомдол гаргасан:

а)Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ХБНГУ-ын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагдсан. Уг хуульд заасны дагуу талууд арбитрын шийдвэрийг хүлээн авснаас хойш 3 сарын хугацаанд хүсэлт гаргаж, шийдвэрийг засварлуулах, тайлбарлуулах боломжтой байдаг. Энэ хугацаа дуусаагүй буюу арбитрын үндсэн шийдвэр эцэслэгдээгүй байхад арбитрын шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа эхлүүлэх нь буруу.

б)Арбитрын шийдвэр Монгол Улсын Газрын тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн холбогдох хэсгүүдийг зөрчсөн буюу хууль болон конвенцод зааснаар Монгол Улсын нийтийн ашиг сонирхол /нийтийн дэг журам/-ыг зөрчсөн нь шүүх арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс татгалзах нөхцөл байдал тогтоогдоогүй.

Шүүх талуудын хоорондын эрх зүйн маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй байх буюу мөн Конвенцын 5 дугаар зүйлийн 1(е)-д заасны дагуу “арбитрын шийдвэр талуудын хувьд эцсийнх болоогүй” гэсэн буюу эхний үндэслэлийн дагуу Швейцарын танхимын дэргэдэх арбитрын шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон гэж үзэхээргүй нөхцөл байдал үүссэн байх тул шийдвэрийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсан захирамж



МОНГОЛЫН АРБИТРАЖИЙН ХАМТРАН ГҮЙЦЭТГЭХТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААНЫГ ШВЕЙЦАРЫН ТАНХИМЫН ДЭРГЭДЭХ АРБИТР ХЯНАН ШИЙДВЭРЛЭЭД ШИЙДВЭР 2021 ОНЫ 10 ДУГААР САРЫН 28-НД ГАРСАН. БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧ АРБИТРЫН ҮНДСЭН ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БАТАЛГААЖУУЛЖ, ГҮЙЦЭТГЭХ ХУУДАС ОЛГОХ ЗАХИРАМЖИЙГ 2021 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДӨР ГАРГАСАН. ЗАХИРАМЖИЙГ ДООРХ ҮНДСЭЛЭЛЭЭР ХҮЧИНГҮЙ БОЛГОХООР ХЭРГИЙН ХАРИУЦАГЧ ТАЛ ШҮҮХЭД ГОМДОЛ ГАРГАСАН:



МОНГОЛ АРБИТРЫН ХАРИУЦЛАГА

болон шийдвэр гүйцэтгэх хуудсыг тус тус хүчингүй болгож шийдвэрлэсэн нь хууль ёсны дагуу гарсан шийдвэр гэж үзэж байна.

Харин Арбитрын ажиллагаа хэлэлцээр болон хуульд заасан журмын дагуу явагдсан эсэхийг хянах үүрэг шүүхэд байхгүй гагцхүү хариуцлага хүлээх талын үүрэг байхаар хууль болон конвенцын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт зохицуулсан атал шүүгч захирамж гаргаж шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан нь хуулийг буруу хэрэглэж алдаатай шийдвэр гаргасан гэж дүгнэж байна.

Тухайлбал, ОХУ-ын хуулийн этгээд болох “Г”, Монгол Улсын хуулийн этгээд болох “А” ХХК-тай 2006 онд байгуулсан зээлийн гэрээтэй холбоотой маргааныг Москва хотын арбитрын шүүх 2012 оны 7 дугаар сард эцэслэн шийдвэрлэсэн. Шийдвэрийг биелүүлэхээр Монгол Улсын дүүргийн шүүхээс 2014 оны 2 дугаар сард сонирхогч талын хүсэлтээр баталгаажуулж гүйцэтгэх хуудас олгосон. Гэтэл талуудын маргасан зээлийн шугам нээх гэрээний 6.4 дэх заалтыг хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцох “Б” ХХК-ийн нэхэмжлэлтэй хэргийг Хан-Уул дүүргийн шүүх ердийн журмаар дахин хянаад нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэжээ. Нэхэмжлэгч тал шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөлийн улмаас хянуулах хүсэлт гарган улмаар уг хэргийг ердийн журмаар дахин хянан хэлэлцэж байгаа нь нотлогдож байх тул арбитрын шийдвэрийг баталгаажуулсан өмнөх шийдвэрээ хүчингүй болгосон захирамж гаргажээ. Захирамждаа “Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх тухай 1958 оны конвенцын 5 дугаар зүйлийн 1-ийн “Арбитрын шийдвэрээр хариуцлага хүлээх тал гагцхүү дараах нотолгоог эрх бүхий байгууллагад гаргаж өгсөн нөхцөлд арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс татгалзаж болно” гэсэн заалтыг үндэслэсэн атлаа шүүгч өөрийн алдааг залруулж шийдвэрээ хүчингүй болгох заалт буюу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон захирамжилжээ. Өөрөөр

хэлбэл арбитрын шийдвэрээр хариуцлага хүлээх талд хамаарах зохицуулалтыг шүүгч үндэслэл болгож өөрийн гаргасан захирамжаа хүчингүй болгож байгаа нь хууль буруу хэрэглэсэн алдаатай шийдвэр болжээ.

Мөн нэхэмжлэгч ОХУ-ын үйлдвэрийн газар, хариуцагч Монгол Улсын “Г” ХХК нарын маргааныг Москва хотын Арбитрын шүүх 2018 оны 10 дугаар сарын 03-ны өдөр хянан шийдвэрлээд шийдвэр нь 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч “Б” Москва хотын Арбитрын шүүхийн шийдвэрийг баталгаажуулах тухай хүсэлтийг Орхон аймгийн сум дундын шүүхэд хүргүүлж хүсэлтийг 2020 оны 6 дугаар сард хангасан. Хариуцагч хуульд заасан хугацаанд уг захирамжид гомдол гаргаагүй учир захирамж хүчин төгөлдөр болж гүйцэтгэх хуудас үйлдэж 2020 оны 8 дугаар сарын 17-ны өдөр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхэлсэн. 2021 оны 9 дүгээр сарын 17-нд хариуцагч “Г” ХХК “шүүх хуралдаанд биеслэн оролцуулахгүйгээр хуралдаж шийдвэр гаргасан нь Арбитрын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.1.б, Мөн НҮБ, Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх тухай конвенц (1958)-ийн оны 5.1.б-д заасан үндэслэлээр Монгол Улс арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс татгалзах үндэслэл байна” гэж шүүхэд гомдол гаргасныг шүүх өмнөх захирамжид гомдол гаргах хуульд заасан хугацаа өнгөрсний дараа хүлээн авч нэхэмжлэгч талд мэдэгдэлгүй хүсэлтийг хангаж шийдвэрийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсан өмнө гаргасан захирамж болон гүйцэтгэх хуудсыг тус тус хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. Шүүх үндэслэлдээ арбитрын шийдвэрийг баталгаажуулахдаа шийдвэрийг гүйцэтгэхээс татгалзах үндэслэл байгаа эсэхийг хянах үүргийг хэрэгжүүлэх процесс ажиллагааг шүүх явуулаагүй гэж дурджээ. Арбитрын ажиллагаа арбитрын хэлэлцээр болон хуульд заасан журмын дагуу явагдсан эсэхийг хянах үүрэг шүүхэд байхгүй гагцхүү хариуцлага хүлээх талын



үүрэг байхаар хууль болон конвенцод зохицуулсан. Гэтэл хуулийг буруу хэрэглэн үндэслэлгүй шийдвэр гаргаад зогсохгүй захирамжид гомдол гаргах хугацаа дууссанаас хойш 1 жилийн дараа гарсан гомдлыг хүлээн авч хангаж шийдвэрлэсэн байна.

Зарим шүүгчийн тухайд гадаадын арбитрын шийдвэрийг баталгаажуулах захирамж гаргахдаа тухайн захирамжид гомдол гаргах эрхгүй болохыг дурдсан байна. Тодруулбал; Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар Хонг Конгын Олон улсын арбитрын шүүхийн шийдвэрийг баталгаажуулахдаа, Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар Хятадын Олон улсын Эдийн засаг, Худалдааны арбитрын хорооны шийдвэрийг баталгаажуулахдаа ИХШХШТХ-ийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэгт зааснаар буюу холбогдолгүй заалтыг дурдаж, мөн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн захирамжаар Чех улсын арбитрын шүүхийн шийдвэрийг баталгаажуулах захирамж гаргахдаа тус тус тухайн захирамжид гомдол гаргах эрхгүй талаар заалт оруулсан байна.

Гадаадын арбитрын шийдвэрийг баталгаажуулахаар гаргасан шүүгчийн захирамжид гомдол гаргах боломжтой эсэх тухайд судлан үзвэл шийдвэрийг баталгаажуулахаар гаргасан шүүгчийн захирамжид гомдол гаргаж захирамжийг хүчингүй болгохдоо ИХШХШ тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт заасан шүүгчийн захирамж илт үндэслэл муутай бол тухайн шүүгч захирамж гарган хүчингүй болгох зохицуулалт, эсхүл мөн хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1 дэх хэсэгт заасан шүүгчийн захирамжид заасан гомдлыг 14 хоногийн дотор тухайн хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгчийг оролцуулахгүйгээр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж захирамжийг хүчингүй болгох тогтоол гаргах зохицуулалтын аль нэгийг баримтлан шийдвэрлэж байгаа практик байна. ИХШХШ тухай хуулийн 124 дүгээр

зүйлийн 124.1 дэх хэсэгт заасан шүүгчийн захирамж илт үндэслэл муутай бол тухайн шүүгч захирамж гарган өөрөө хүчингүй болгох, өөрчлөх зохицуулалт бол шүүх бүрэлдэхүүн, шүүгч илт үндэслэл муутай гаргасан өөрийн шийдвэрийнхээ алдааг залруулах зорилготой, харин тус хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1 дэх хэсэг бол гомдлоор хэрэг үүсгэн хянан шийдвэрлэж байгаа тул өмнө шийдвэрлэсэн бүрэлдэхүүн, эсхүл шүүгчээс өөр этгээд шийдвэр гаргах эрх зүйн зохицуулалтыг практикт ялгаатай байдлаар ойлгож хэрэглэх нь зүйтэй байна.

Энэхүү алдаа нь зөвхөн гадаад улсын арбитрын шийдвэрт ч бус дотоодын маргаан дээр нийтлэг ажиглагдаад зогсохгүй дотоодын арбитрын шийдвэрийг агуулгын хувьд шүүхээс хянаж байгаа практик сүүлийн үед гарч байна. Тухайлбал Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 101/ШЗ2024/03196 дугаар захирамжаар “Х” ББСБ ХХК-ийн иргэнтэй байгуулсан зээлийн маргааныг эвлэрлийн гэрээгээр баталгаажуулан шийдвэрлэсэн арбитрын шийдвэрийг баталгаажуулах хүсэлтийг шийдвэрлэхдээ “...шийдвэр нь салаа утгатай, математик тооцооллын хувьд алдаатай...” гэх мэтээр арбитрын шийдвэрийн агуулгад халдаад зогсохгүй “уг захирамжид гомдол гаргах эрх хуулиар олгогдоогүйг дурдсугай” хэмээн хууль хэрэглээний маш ноцтой, бүдүүлэг алдаа гаргажээ. Шүүгч энэхүү захирамжаараа арбитрын шийдвэрийн эцсийн бөгөөд заавал биелэгдэх зарчмыг алдагдуулж байгаа бөгөөд уг шийдвэр өнөөдөр биелэгдэх боломжгүй болж, төлбөр авагч юу хийх, хэнд хандахаа мэдэхгүй байдалтай байна.

Түүнчлэн, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх нь Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу арбитрын шийдвэрийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгох гомдлын дагуу хянаж, арбитрын шийдвэрийг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэж байгаа бөгөөд Арбитрын тухай хуулийн 47.5-д зааснаар шүүхийн



МОНГОЛЫН АРБИТРАЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ



ᠮᠣᠩᠭᠡᠯᠢ ᠠᠷᠢᠪᠢᠲᠤᠷᠢᠨ  
 ᠮᠤᠮᠤᠯᠠᠭᠤᠨ ᠠᠷᠢᠪᠢᠲᠤᠷᠢᠨ  
 ᠮᠤᠮᠤᠯᠠᠭᠤᠨ ᠠᠷᠢᠪᠢᠲᠤᠷᠢᠨ

энэхүү шийдвэр эцсийн байна. Сүүлийн үед практикт Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс арбитрын шийдвэрийн агуулгад орж шийдвэрийг хуульд зааснаас бусад үндэслэлээр хүчингүй болгож, улмаар тэрхүү шийдвэрээ эцсийн шийдвэр гэж магадлалдаа дурдаж хүний эрхэд ноцтой халдах тохиолдлууд гарч байна

Шүүхээс арбитрын шийдвэрийг хүчингүй болгох, шийдвэрийг биелүүлэхээс татгалзах үндэслэл бол

гагцхүү Арбитрын тухай хуулийн 47 болон 49 дүгээр зүйлд зааснаас бусад үндэслэл байж болохгүй юм.

Улсаар ангилбал, ОХУ-ын арбитрын 13, БНХАУ-ын арбитрын 4, Хонконгийн арбитрын 1, БНСУ-ын арбитрын 1 шийдвэрийг баталгаажуулах хүсэлт гаргажээ. Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн мэдээлэлд улсаар ангилсан мэдээлэл тусгагдаагүй байна.



График 4. Нийслэлийн 9 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс гадаад улсын арбитрын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулсан байдал (2019-2023)

Арбитрын тухай хуулийн 49 дүгээр зүйлд Арбитрын шийдвэрийг татгалзах үндэслэлийг тодорхой заасан боловч хариуцагчийн хаяг буруу, улсын тэмдэгтийн хураамжийг хуульд заасан журмын дагуу төлөөгүй, шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болсон эсэх талаар баримтыг хавсаргаагүй, арбитрын шийдвэрийг талуудад хүргүүлээгүй, шүүхийн харьяаллыг зөрчиж хүсэлт гаргасан, хариуцагч тал шийдвэрт давж заалдах гомдол гаргасан эсэх, шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон эсэх нь тодорхойгүй, компанийг төлөөлөх эрхтэй этгээд хэн эсэх нь тодорхойгүй, энэ талаарх баримтаа хүсэлтэд хавсаргаагүй, хуульд заасан журмаар олгоогүй итгэмжлэлээр шүүхэд хүсэлт гаргасан гэх мэт хуульд зааснаас бусад үндэслэлээр болон шийдвэр гүйцэтгүүлэхийг сонирхогч талын шүүхэд нотлох үүргийг шүүх гүйцэтгэж арбитрын шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан нь шүүхээс ирүүлсэн мэдээллээс харагдаж байгаа боловч үүнийг шийдвэр биелүүлэхээс татгалзсан захирамж бус,

харин хүсэлт хангахаас татгалзсан захирамж гаргасан гэж найдаж байна.

2011-2024 оны хооронд Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба нь гадаад улсын арбитрын нийт 96 шийдвэрт гүйцэтгэх ажиллагаа явуулж 33 шийдвэрийг гүйцэтгэсэн статистикийг харвал арбитрын шийдвэр гүйцэтгэлийн чанар төдийлөн хангалттай биш гэж үзэж байна.

Үүнийг мөн Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар 2024 онд хийж гүйцэтгэсэн 2017 оны Арбитрын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг судалсан судалгаанд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх баримт бичиг бүхий дотоодын болон гадаадын арбитрын шийдвэрийн биелэлт хангалттай бус байна. Мөн статистик датаг үндэслэн, гадаадын арбитрын шийдвэр биелэлт дотоодынхоос бага боловч үнийн дүнгээр харьцангуй илүү байгаа нь ажиглагдаж байна. Мөн шүүхэд арбитрын ажиллагаатай холбоотой маргаан бусад салбарын маргаантай харьцуулбал цөөн байдаг ба Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийг үндэслэн

арбитрын харьяаллын маргаан мөн эсэх талаар шийдвэрлэдэг байна. Дээрх судалгааны тоо баримт нь Арбитрын тухай хуулийн 48, 49 дүгээр зүйлийн практик хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэх бөгөөд харьяаллын заалтыг тодорхой болгох, арбитрын шийдвэрийг гүйцэтгэх процессыг хөнгөвчлөх зэрэгт чиглэсэн үйл ажиллагаа нь практикт хэрэгжих байдлыг нэмэгдүүлэх боломжтой” гэж дүгнэжээ. (Уянга нар, 2024)

2017 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 116 дугаар зүйлд “Гадаад улсын болон олон улсын шүүх, арбитрын шийдвэрийг гүйцэтгэх” гэсэн зохицуулалт байх бөгөөд 116.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад улсын, олон улсын шүүх, арбитрын шийдвэрийг гүйцэтгэх журмыг энэ хууль, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлно” гэж ерөнхий байдлаар хуульчилсан байна.

2024 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Сингапурын Олон Улсын Арбитрын Төвийн шийдвэр Монгол Улсад хэрхэн биелэгдэхгүй байгаа сонирхолтой жишээг энд дурдъя.

Монгол Улсын “Э” ХХК болон Япон Улсын хөрөнгө оруулалттай “М” ХХК нарын хооронд 2015 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан №5/262-15 бүртгэлийн дугаартай Ерөнхий гэрээ, дэд гэрээтэй холбоотой маргааныг Сингапурын Олон Улсын Арбитрын Төвийн 2024 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 012 дугаартай арбитрын шийдвэрээр “Э” ТӨҮГ-аас төлбөр гаргуулан “М” нийгэмлэгт олгохоор шийдвэрлэжээ.

Ийнхүү хариуцагч Орхон аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан хүсэлтдээ “Сингапурын Олон Улсын Арбитрын Төвийн шийдвэрийн дагуу төлөгдөх нийт төлбөрийг хариуцагчаас албадан гаргуулах тухай Арбитрын шийдвэрийг албадан биелүүлэх захирамж, шүүхийн гүйцэтгэх хуудасны хамтаар олгож өгнө үү...” гэжээ.

Шүүх хүсэлтийг хянан үзээд “арбитрын үндсэн шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэхээс татгалзах үндэслэл тогтоогдохгүй байх тул Иргэний хэрэг

шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 184.1-д... заасны дагуу... шийдвэрийн гүйцэтгэлийг баталгаажуулах нь зүйтэй гэж үзлээ” хэмээн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх захирамжийг 2024 оны 7 дугаар сарын 04-ний өдөр гаргажээ. (Орхон аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх, 2024)

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн өмчит бус, харин төрийн өмчийн оролцоотой ХХК байсан зэрэг эрх зүйн байдал нь “Э” төв эмнэлгийн үл хөдлөх хөрөнгийг бусдад хариу төлбөртэй худалдан, шилжүүлсэн хэлцэл нь Иргэний хуулийн 243 дугаар зүйлд тодорхойлсон худалдах-худалдан авах хэлцлийн шинжтэй, хуульд нийцсэн үйл ажиллагаа боловч “Э” ХХК-ийн ТУЗ-өөс эрх бүхий этгээд буюу гүйцэтгэх удирдлагад зөвшөөрөл олгоогүй байх тул Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.8-д заасан зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хүчин төгөлдөр бус хэлцэл хийгдсэн байх нь зарим эрх бүхий байгууллагын шалгалтаар нотлогдсон байна. Тухайлбал, Зөрчил арилгуулах тухай 2019 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын улсын ахлах байцаагчийн албан даалгаварт “Э” ХХК нь Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг зөрчин “М” ХХК-тай гэрээ байгуулсан гэж дүгнээд цуцлах шаардлагатай хэмээн үзсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсгийн “...Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно...” гэж заасныг зөрчиж төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр шилжүүлсэн байна гэж дүгнэжээ.

Энэхүү дүгнэлт нь арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзах хангалттай үндэслэл болох нь



МОНГОЛ УЛСЫН АРБИТРЫН ТӨВИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ХУУЛЬ



харагдаж байна. Өөрөөр хэлбэл, Арбитрын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.1.а-д заасан буюу “...арбитрын хэлэлцээрийн аль нэг тал эрх зүйн чадамжгүй, эсхүл арбитрын хэлэлцээр нь талуудын тохиролцон сонгосон улсын хуульд зааснаар, эсхүл тохиролцон сонгоогүй бол хуульд зааснаар хүчин төгөлдөр бус” байвал арбитрын шийдвэрийг татгалзах үндэслэлийг үүрэг хүлээгч тал шүүхэд нотолбол арбитрын шийдвэрийг биелүүлэхээс татгалзаж болох байсан.

Анхаарал хандуулах шаардлагатай асуудал нь Сингапурын Олон Улсын Арбитрын Төвийн шийдвэрийг шүүхээс албадан гүйцэтгүүлэх тухай захирамж гарсны дараа хариуцагч тал захирамжийг гардан авмагц шийдвэрийг хүчингүй болгох хүсэлтээ гаргаж биелүүлэхээс татгалзуулах боломж байхад эс үйлдлээрээ захирамжийг хэвээр үлдээх боломж бий болгосон явдал юм.

Энэхүү хэргийн оролцогчид авлига, албан тушаалын хэрэгт шалгагдаж байгаа тул шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлсэн байдалтай байна.

### Дүгнэлт

1. Арбитрын шийдвэрийг баталгаажуулах ажиллагаанд хуулийн зохицуулалтыг нэг мөр ойлгож хэрэглэх шаардлагатай байна. Шүүгч бүрийн мэдлэг, ур чадварын түвшин, хандлагатай холбоотой мэт боловч нэг асуудлыг хамааралтай, хамааралгүй олон үндэслэлээр, эсхүл огт үндэслэл дурдахгүйгээр шийдвэрлэж байгаа нь хууль хэрэглээний хувьд алдаа үүсгэхээс гадна харилцан адилгүй үр нөлөөтэй байна.

2. Арбитрын ажиллагаа арбитрын хэлэлцээр болон хуульд заасан журмын дагуу явагдсан эсэхийг хянах үүрэг шүүхэд байхгүй, гагцхүү хариуцлага хүлээх тал нотолсны үндсэн дээр арбитрын шийдвэрийг шүүхээс үл хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс татгалзаж захирамжлан шийдвэрлэхээр Арбитрын тухай хуулийн 49.1.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184.3. дахь заалт болон Конвенцын 5 дугаар зүйлийн 1-д зохицуулсан.

3. Гадаадын арбитрын шийдвэрийг баталгаажуулахаас татгалзах захирамж гаргахдаа тухайн захирамжид гомдол гаргах эрхгүй болохыг дурдах нь арбитрын шийдвэр эцсийн бөгөөд заавал биелэгдэх олон улсын зарчмыг алдагдуулж байна. Гадаадын арбитрын шийдвэрийг баталгаажуулахаар гаргасан шүүгчийн захирамжид гомдол гаргаж захирамжийг хүчингүй болгохдоо ИХШХШТ хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэг, эсхүл мөн хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1 дэх хэсэгт зохицуулалтын аль нэгийг баримтлан шийдвэрлэж байгаа практик байна. ИХШХШТ хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт заасан шүүгчийн захирамж илт үндэслэл муутай бол тухайн шүүгч өөрөө захирамж гарган хүчингүй болгох, өөрчлөх зохицуулалт бол шүүх бүрэлдэхүүн, шүүгч илт үндэслэл муутай гаргасан өөрийн шийдвэрийнхээ алдааг залруулах зорилготой, харин тус хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1 дэх хэсэг бол гомдлоор хэрэг үүсгэн хянан шийдвэрлэж байгаа тул өмнө шийдвэрлэсэн бүрэлдэхүүн, эсхүл шүүгчээс өөр этгээд шийдвэр гаргах эрх зүйн зохицуулалтыг практикт ялгаатай байдлаар ойлгож хэрэглэх нь зүйтэй байна.

4. Гадаадын арбитрын шийдвэр биелүүлэхээс татгалзах асуудал нь дотоодын арбитрын шийдвэрийг баталгаажуулах ажиллагаатай харьцуулахад олон улсын эрх зүйн зөрчилдөөний эрх зүйн зохицуулалтыг илүү нягтлах шаардлагатай, адармаатай ажиллагаа тул үүрэг хүлээгч тал нотлох баримтаа бүрдүүлж шүүхэд гаргах болон төлбөр хүлээн авагчийн шүүхэд гаргасан хүсэлттэй танилцах боломжийг бүрдүүлэх, мөн хариу тайлбар өгөх боломжоор хангах талаар тодорхой зохицуулалт байхгүйгээс эрх бүхий байгууллага талуудын оролцоог хангахгүйгээр татгалзах хүсэлтийг шийдвэрлэж байна.

### Ашигласан материал

Монгол Улсын Их Хурал. (2017). *Үндсэн хууль*. Улаанбаатар.  
 Монгол Улсын Их Хурал. (2017). *Арбитрын тухай хууль*. Улаанбаатар.

- Монгол Улсын Их Хурал. (1992). *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль*. Улаанбаатар.
- Монгол Улсын Их Хурал. (2017). *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль*. Улаанбаатар.
- Нэгдсэн Үндэстний Байгууллага. (1958). *Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай конвенц (Нью-Йоркийн конвенц)*. Нью-Йорк.
- Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх. (2016 оны 10 сарын 3). Лондоны арбитрын шүүхийн шийдвэрийг баталгаажуулах тухай шүүгчийн захирамж, 181/ШЗ2016/04858.
- Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх. (2017 оны 9 сарын 28). Лондоны Олон Улсын Арбитрын шүүхийн шийдвэрийг баталгаажуулах тухай шүүгчийн захирамж, 181/ШЗ2017/12823.
- Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх. (2016 оны 11 сарын 28). Москва хотын арбитрын шүүхийн шийдвэрийг баталгаажуулах тухай шүүгчийн захирамж, 101/ШЗ2016/32286.
- Орхон аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх. (2024 оны 7 сарын 4). Сингапурын Олон Улсын Арбитрын төвийн шийдвэрийг биелүүлэх тухай шүүгчийн захирамж, 142/ШЗ2024/03999.
- Сонгинохайрхан дүүргийн шүүх. (2010 оны 4 сарын 23). Чех Улсын Прага хотын Эдийн засаг, хөдөө аж ахуйн танхимын дэргэдэх арбитрын шүүхийн шийдвэрийг баталгаажуулах тухай шүүгчийн захирамж, 1855.
- Энхцэцэг, С., Доржготов, А., & Мэндсайхан, Т. (2020). *Монгол Улс дахь арбитрын байгууллага: Түүхэн товчоон (1930–2020)*. Улаанбаатар.
- Болормаа, Ч. (2022). Арбитрын шийдвэрийг баталгаажуулах, гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. *Монголын Олон Улсын Арбитр: Шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх нь* (х. 84–85). Улаанбаатар.
- Уянга, М., & Нинжин, Б. (2024). Арбитрын тухай 2017 оны хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгааны тайлан. Улаанбаатар.
- Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар. (2024). Гадаад улсын арбитрын шийдвэрийн гүйцэтгэх ажиллагааны статистик. Улаанбаатар.
- Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар. (2024 оны 4 сарын 17). Монгол Улс дахь гадаадын арбитрын шийдвэрийн биелэлт. (С. Энхцэцэгтэй хийсэн ярилцлага).
- Дэлхийн банк. (2020 оны 8 сарын 27). *Doing Business: Монгол Улс дахь бизнесийн орчин*. Retrieved from <https://archive.doingbusiness.org/en/doing-business>



Арбитрын шийдвэр гүйцэтгэх газар  
 Арбитражный суд  
 Арбитраж